# ХААН СОЁМБО АУДИТ ХХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2023/110/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Хөвсгөл аймаг<br>2023 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар<br>Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр<br>Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn<br><br>Аудитор: Г.Ичинхорлоо<br>Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorloog@audit.gov.mn<br><br>Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа<br>Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn<br><br>Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Магсаржалам<br>Утас: 88114867 Цахим хаяг: khaan.soyombo.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Агуулга**


1.АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 15
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 15
3.5.1 Төсвийн төлөвлөлт ........ 15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл ........ 16
3.5.3 Нэмэлт төсөв ........ 16
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ........ 16
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 16
4.1 Ерөнхий зүйл ........ 16
4.2 Материаллаг байдал ........ 17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 17
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 17
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ........ 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 18
5.1 Төлбөрийн акт ........ 18
5.2 Албан шаардлага ........ 18
5.3 Зөвлөмж ........ 18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/179

танай ______________ -ны № ______________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦЭЦЭРЛЭГ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Х.ЭНХСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэрлэг сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цэцэрлэг сумын Эрүүл Мэндийн Төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэлийг 2022 оны 1 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг эрүүл мэндийн даатгалын санд нэгтгэж, гүйцэтгэлд суурилан санхүүжүүлсэн байна. Тус байгууллага нь гүйцэтгэлээр санхүүжилт авсан боловч мөнгөн хөрөнгийн дансанд 131,167.1 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдэлтэй байна.

**Аудитын гол асуудал**

Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаардлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 61,231.9 мянган төгрөгийн эмийн шууд худалдан авалт хийсэн.

Цэцэрлэг сумын ЗДТГ-аас 2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр тус сумын ЭМТ-ийн нэр дээр 88,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий Прадо-150 суудлын авто машиныг худалдан авах тендер зарлаж сумын ИТХ-ын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 06-р тогтоолоор ЭМТ-ийн хөрөнгөнд шилжүүлэх тогтоол гарсан байна. ЭМТ нь хөрөнгийг биетээр хүлээж аваагүй байж данс бүртгэлд тусгасан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Цэцэрлэг сумын Эрүүл Мэндийн Төв нь 2022 онд 8 зорилтын хүрээнд 82 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 1.4 хувийн гүйцэтгэлтэй ажилласан.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ СТ-1А

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **181,547,079.11** | **299,580,161.67** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 00.00 | 131,167,102.50 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 00.00 | 131,167,102.50 |
| **3121** | **Төгрөг** | 00.00 | 131,167,102.50 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 131,167,102.50 |
| **33** | **АВЛАГА** | 66,512,047.00 | 00.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 47,923,100.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 18,588,947.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 18,588,947.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 115,035,032.11 | 168,413,059.17 |
| **351** | **Түүхий эд материал** | 63,862,173.78 | 51,892,330.91 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 22,758,847.80 | 00.00 |
| 35130 | Эм боох материал | 41,103,325.98 | 51,892,330.91 |
| **354** | **Хангамжийн материал** | 48,322,858.33 | 113,670,728.26 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,623,960.00 | 5,640,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,740,999.00 | 22,017,778.47 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,492,000.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,125,997.50 | 6,564,456.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 34,339,901.83 | 79,448,393.79 |
| 35600 | Мал амьтад | 2,850,000.00 | 2,850,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **517,132,290.34** | **618,496,143.37** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 517,132,290.34 | 618,496,143.37 |
| **392** | **Биет хөрөнгө** | 497,597,290.34 | 598,881,393.34 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 327,225,476.00 | 339,314,680.90 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -45,793,807.36 | -62,154,960.56 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 61,743,792.00 | 152,889,792.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -16,093,620.18 | -27,577,779.94 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 169,764,531.00 | 227,640,185.29 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -46,171,802.82 | -81,703,060.97 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 56,843,227.00 | 69,375,857.36 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -9,920,505.30 | -18,903,320.74 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 19,535,000.00 | 19,614,750.03 |
| 39301 | Програм хангамж | 935,000.00 | 1,155,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | -140,249.97 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 18,600,000.00 | 18,600,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **698,679,369.45** | **918,076,305.04** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **698,679,369.45** | **918,076,305.04** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 698,679,369.45 | 918,076,305.04 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 889,082,412.08 | 889,082,412.08 |
| 51101 | Өмч: - төрийн | 889,082,412.08 | 889,082,412.08 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -426,379,577.41 | -206,982,641.82 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -426,379,577.41 | -426,379,577.41 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 219,396,935.59 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 235,976,534.78 | 235,976,534.78 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **698,679,369.45** | **918,076,305.04** |

**СТ-2А**

## 2.2 Санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,481,025,172.10** | **1,174,791,704.57** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,103,888,902.10** | **220,600,384.57** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 486,164,162.10 | 220,600,384.57 |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **00.00** | **1,019,000.00** |
| 120010 | Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/ | 00.00 | 1,019,000.00 |
| 122 | Тусламжийн орлого | 36,567,540.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 36,567,540.00 | 00.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 581,157,200.00 | 00.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 581,157,200.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **377,136,270.00** | **954,191,320.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **317,937,270.00** | **579,500.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 5,297,100.00 | 579,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 68,721,170.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,564,000.00 | 00.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 240,355,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **59,199,000.00** | **67,646,600.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 59,199,000.00 | 67,646,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **00.00** | **885,965,220.00** |
| **134002** | **Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих** | **00.00** | **885,965,220.00** |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,280,529,203.42** | **955,394,768.98** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,280,529,203.42** | **955,394,768.98** |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,232,129,203.42 | 949,411,813.98 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **546,127,187.00** | **513,464,770.50** |
| 210101 | Үндсэн цалин | 538,377,187.00 | 366,838,365.33 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 114,681,139.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 7,461,000.00 |
| 210104 | Урамшуулал | 7,750,000.00 | 24,484,266.17 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **67,774,385.00** | **56,143,780.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,539,946.64 | 39,114,648.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,364,258.96 | 4,105,205.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,491,405.97 | 4,074,008.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 852,616.68 | 986,295.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,526,156.76 | 7,863,624.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **59,303,300.00** | **61,116,030.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,289,158.00 | 2,979,061.00 |
| 210302 | Түлш, халаалт | 50,626,763.00 | 49,718,769.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,387,379.00 | 8,418,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **51,664,221.00** | **54,963,267.20** |
| 210401 | Бичиг хэрэг | 2,833,206.00 | 2,138,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,839,670.00 | 42,884,210.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,840,000.00 | 2,178,666.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 139,487.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 918,780.00 | 2,483,300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,093,078.00 | 5,278,891.20 |
| **2105** | **Нормативт зардал** | **439,048,587.04** | **140,465,915.76** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 427,709,117.84 | 133,618,778.76 |
| 210502 | Хоол, хүнс | 11,214,469.20 | 6,847,137.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 125,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,644,250.00** | **36,022,611.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,733,500.00 | 8,941,211.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,910,750.00 | 27,081,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,294,000.00** | **702,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,294,000.00 | 702,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **4,182,602.00** | **3,170,987.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 521,400.00 | 566,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 550,000.00 | 890,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 169,500.00 | 330,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,000.00 | 62,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 00.00 | 12,375.00 |
| 210807 | Газрын төлбөр | 303,168.00 | 319,112.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,548,534.00 | 990,300.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **52,090,671.38** | **83,362,452.52** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,912,713.00 | 9,369,401.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 47,177,958.38 | 73,993,051.52 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **48,400,000.00** | **5,982,955.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 48,400,000.00 | 00.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 48,200,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **00.00** | **5,982,955.00** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 5,982,955.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **200,495,968.68** | **219,396,935.59** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **44,832,758.33** | **00.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 44,832,758.33 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-44,832,758.33** | **00.00** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **155,663,210.35** | **219,396,935.59** |

## 2.3 Мөнгөн гүйлгээний тайлан СТ-3А

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **946,937,910.00** | **1,003,133,420.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **617,724,740.00** | **00.00** |
| **122** | **Тусламжийн орлого** | 36,567,540.00 | 00.00 |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 36,567,540.00 | 00.00 |
| **123** | **Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг** | 581,157,200.00 | 00.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 581,157,200.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **329,213,170.00** | **1,003,133,420.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 270,014,170.00 | 1,598,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 68,721,170.00 | 579,500.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,564,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 59,199,000.00 | 67,646,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 59,199,000.00 | 67,646,600.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 00.00 | 933,888,320.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 00.00 | 933,888,320.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **946,937,910.00** | **871,966,317.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **946,937,910.00** | **871,966,317.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **898,537,910.00** | **865,983,362.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 546,127,187.00 | 513,024,770.35 |
| 210101 | Үндсэн цалин | 437,857,459.00 | 366,479,493.00 |
| 210102 | Нэмэгдэл | 63,299,620.00 | 114,684,139.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,269,200.00 | 7,461,000.00 |
| 210104 | Урамшуулал | 31,029,338.00 | 24,400,138.35 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,671,570.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 67,774,385.00 | 56,143,780.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 50,377,885.00 | 39,486,149.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,349,100.00 | 4,223,375.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,479,300.00 | 3,372,020.31 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 869,800.00 | 823,803.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,698,300.00 | 8,238,431.41 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 59,303,300.00 | 61,116,030.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,289,158.00 | 2,979,061.00 |
| 210302 | Түлш, халаалт | 50,626,763.00 | 49,717,769.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,387,379.00 | 8,419,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 51,936,747.00 | 59,968,376.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,240,000.00 | 3,456,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 39,839,670.00 | 42,884,210.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,840,000.00 | 3,625,666.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 139,487.00 | 30,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 785,000.00 | 4,190,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,092,590.00 | 5,781,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 131,657,223.00 | 95,152,666.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 120,396,878.00 | 79,573,542.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,622,345.00 | 12,554,124.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,638,000.00 | 3,025,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 28,057,000.00 | 67,925,200.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 00.00 | 22,282,000.00 |
| 210602 | Тавилга | 18,777,000.00 | 9,024,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,200,000.00 | 9,997,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,080,000.00 | 26,621,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,294,000.00 | 702,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,294,000.00 | 702,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,715,968.00 | 3,600,327.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 521,400.00 | 566,400.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 550,000.00 | 890,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 169,500.00 | 330,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 90,000.00 | 62,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 00.00 | 12,375.00 |
| 210807 | Газрын төлбөр | 303,168.00 | 319,112.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,081,900.00 | 1,419,640.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,672,100.00 | 8,350,213.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,672,100.00 | 8,350,213.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **48,400,000.00** | **5,982,955.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 48,400,000.00 | 00.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 48,200,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 5,982,955.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 5,982,955.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **157,955,102.50** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | 26,788,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | 26,788,000.00 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 26,788,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 26,788,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **26,788,000.00** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **00.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 131,167,102.50 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 131,167,102.50 |

## 2.4 Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан СТ-4А

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **889,082,412.08** | **235,976,534.78** | **-426,379,577.41** | 698,679,369.45 |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **889,082,412.08** | **235,976,534.78** | **-426,379,577.41** | 698,679,369.45 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **889,082,412.08** | **235,976,534.78** | **-426,379,577.41** | 698,679,369.45 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 219,396,935.59 | 219,396,935.59 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **889,082,412.08** | **235,976,534.78** | **-206,982,641.82** | 918,076,305.04 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 | - | 100.00 |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 962,013,700.00 | 865,983,362.35 | 96,030,337.65 | 90.02 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 962,013,700.00 | 865,983,362.35 | 96,030,337.65 | 90.02 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 962,013,700.00 | 865,983,362.35 | 96,030,337.65 | 90.02 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 529,787,000.00 | 513,024,770.35 | 16,762,229.65 | 96.84 |
| 210101 | Үндсэн цалин | 370,164,200.00 | 366,479,493.00 | 3,684,707.00 | 99.00 |
| 210102 | Нэмэгдэл | 124,776,800.00 | 114,684,139.00 | 10,092,661.00 | 91.91 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 7,633,000.00 | 7,461,000.00 | 172,000.00 | 97.75 |
| 210104 | Урамшуулал | 26,278,200.00 | 24,400,138.35 | 1,878,061.65 | 92.85 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 934,800.00 | - | 934,800.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 66,192,100.00 | 56,143,780.00 | 10,048,320.00 | 84.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 46,778,700.00 | 39,486,149.23 | 7,292,550.77 | 84.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,853,300.00 | 4,223,375.23 | 629,924.77 | 87.02 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 3,882,700.00 | 3,372,020.31 | 510,679.69 | 86.85 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 970,600.00 | 823,803.72 | 146,796.28 | 84.88 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,706,800.00 | 8,238,431.51 | 1,468,368.49 | 84.87 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 62,273,900.00 | 61,116,030.00 | 1,157,870.00 | 98.14 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 3,665,800.00 | 2,979,061.00 | 686,739.00 | 81.27 |
| 210302 | Түлш, халаалт | 50,960,200.00 | 49,717,769.00 | 1,242,431.00 | 97.56 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,647,900.00 | 8,419,200.00 | (771,300.00) | 110.09 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 80,700,800.00 | 59,968,376.00 | 20,732,424.00 | 74.31 |
| 210401 | Бичиг хэрэг | 5,118,500.00 | 3,456,700.00 | 1,661,800.00 | 67.53 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 52,534,300.00 | 42,884,210.00 | 9,650,090.00 | 81.63 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 4,505,000.00 | 3,625,666.00 | 879,334.00 | 80.48 |
| 210404 | Ном, хэвлэл | 100,000.00 | 30,000.00 | 70,000.00 | 30.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,401,800.00 | 4,190,500.00 | 3,211,300.00 | 56.61 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 11,041,200.00 | 5,781,300.00 | 5,259,900.00 | 52.36 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2105 | Нормативт зардал | 127,949,000.00 | 95,152,666.00 | 32,796,334.00 | 74.37 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 101,262,700.00 | 79,573,542.00 | 21,689,158.00 | 78.58 |
| 210502 | Хоол, хүнс | 20,922,900.00 | 12,554,124.00 | 8,368,776.00 | 60.00 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 5,763,400.00 | 3,025,000.00 | 2,738,400.00 | 52.49 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 78,519,700.00 | 67,925,200.00 | 10,594,500.00 | 86.51 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 22,420,300.00 | 22,282,000.00 | 138,300.00 | 99.38 |
| 210602 | Тавилга | 9,100,000.00 | 9,024,300.00 | 75,700.00 | 99.17 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 15,553,000.00 | 9,997,500.00 | 5,555,500.00 | 64.28 |
| 210604 | Урсгал засвар | 31,446,400.00 | 26,621,400.00 | 4,825,000.00 | 84.66 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,956,700.00 | 702,000.00 | 1,254,700.00 | 35.88 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,956,700.00 | 702,000.00 | 1,254,700.00 | 35.88 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 4,849,300.00 | 3,600,327.00 | 1,248,973.00 | 74.24 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 566,400.00 | 566,400.00 | - | 100.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 979,000.00 | 890,000.00 | 89,000.00 | 90.91 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 330,300.00 | 330,300.00 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 195,000.00 | 62,500.00 | 132,500.00 | 32.05 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 130,000.00 | 12,375.00 | 117,625.00 | 9.52 |
| 210807 | Газрын төлбөр | 388,600.00 | 319,112.00 | 69,488.00 | 82.12 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 2,260,000.00 | 1,419,640.00 | 840,360.00 | 62.82 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,785,200.00 | 8,350,213.00 | 1,434,987.00 | 85.34 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,785,200.00 | 8,350,213.00 | 1,434,987.00 | 85.34 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 962,013,700.00 | 997,150,465.00 | (35,136,765.00) | 103.65 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 67,646,600.00 | 61,663,645.00 | 5,982,955.00 | 91.16 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 67,646,600.00 | 61,663,645.00 | 5,982,955.00 | 91.16 |
| 1340 | НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 844,880,500.00 | 933,888,320.00 | (89,007,820.00) | 110.53 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 844,880,500.00 | 933,888,320.00 | (89,007,820.00) | 110.53 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 49,486,600.00 | 1,598,500.00 | 47,888,100.00 | 3.23 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 904,500.00 | 939,500.00 | (35,000.00) | 103.87 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 48,582,100.00 | 659,000.00 | 47,923,100.00 | 1.36 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 131,167,102.50 | (131,167,102.50) | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 31.00 | 31.00 | - | 100.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 23.00 | 23.00 | - | 100.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8.00 | 8.00 | - | 100.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэгш байдал хүртээмж чанар, аюулгүй байдлыг хангасан үйлчилгээний стандарт, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг чандлан сахидаг чадварлаг эмч, мэргэжилтэн бүхий төрийн үйлчилгээг төлөвшүүлэх зорилго тавьсан байна.

Цэцэрлэг сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Иргэдийг эрт илрүүлэг хамруулах
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлэх
- Үйлчлүүлэгчдэд болон эмч ажилчдад ээлтэй орчин бүрдүүлэх, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж тасралтгүй байдлыг хангах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан[1] 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан[2] тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:**

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2022

[1] *“Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”*
[2] “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай

оны 05 сарын 24-ны өдрийн А/09 тоот тушаалаар дотоод хяналтын багийг 5 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд нийт 3 заалт бүхий 11 ажлын төлөвлөгөө гаргаж хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. ***Тухайлбал:*** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт *үр нөлөөтэй* байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах *шаардлагагүй* гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:*** Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төв нь Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар 2019 онд баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 219,097.0 мянган төгрөгөөр буюу 31.3 хувиар *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 131,167.1 | 131,167.1 |
| Авлага | 66,512.0 | 0 | -66,512.0 |
| Бараа материал | 115,035.0 | 168,413.7 | -53,378.7 |
| Үндсэн хөрөнгө | 517,132.3 | 618,496.1 | -101,363.8 |
| **Нийт хөрөнгө** | **698,979.3** | **918,076.3** | **-219,097.0** |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 889,082.4 | 889,082.4 | 0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **698,679.3** | **918,076.3** | **-219,097.0** |

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө өмнөх оноос нэмэгдэж, үндсэн хөрөнгө, бараа материал данс өссөн үзүүлэлттэй байна.

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 131,167.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдлийг буцаан төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
2. Бараа материал данс өмнөх оноос 53,378.7 мянган төгрөгөөр өссөн нь хэвтэн эмчлүүлэгчдийн хоол, корона вирусын үеийн бэлэн байдлын нөөц бүрдүүлэлттэй холбоотой байна.
3. Үндсэн хөрөнгө данс 17,905.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 178,662.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн ба төсвийн хөрөнгөөр 26,788.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, 151,874.2 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмжийг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Өмнөх оны Эрүүл мэндийн даатгалаас авах 47,923.1 мянган төгрөг, эм эмнэлгийн хэрэгслийн 18,588.9 мянган төгрөгийн авлага барагдуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгал 933,800.0 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс санхүүжилт 67,646.6 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Нийт зарлагыг 865,983.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийн тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 844,880.5 мянган төгрөгийг Орон нутгийн урсгал санхүүжилтээс үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалаас 844,880.5 мянган төгрөг, Орон нутгийн орлогоос 67,646.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон. Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 865,983.2 мянган төгрөг буюу 91.94 хувьтай байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 4 дүгээр улирлын гүйцэтгэлийн санхүүжилт 2022 оны 12 сарын 25-ны өдөр төрийн сангийн харилцах дансанд орж ирсний улмаас төлөвлөгөөнд тусгаж зардлын эрхийг нээлгээгүй байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нэг иргэнээр тооцсон нормативаар | 447,848.3 | 426,651.1 | 2,197.1 | 95.27 |
| 2 | Үндсэн тусламж үйлчилгээ | 267,099.1 | 251,896.7 | 15,202.3 | 94.31 |
| 3 | Дээд шатны төсвөөс хуваарилсан | 179,419.7 | 125,771.8 | 53,647.8 | 70.10 |
| 4 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 62,273.9 | 61,116.0 | 5,982.8 | 98.14 |
| 5 | Нийтлэг үйлчилгээ | 547.7 | 547.6 | 85.0 | 99,9 |
| | Дүн | 957,188.7 | 865,983.2 | 77,115.0 | 91.94 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2021 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны авлагын үлдэгдэл 66,512.0 мянган төгрөгийг барагдуулж нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдлийг улсын төсвийн харилцах данс руу бичилт хийж тайлагнасан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "бага" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,280,529.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 25,610.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 17,927.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй 61,806.9 мянган төгрөгийн 3 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн тул зөвлөмж хүргүүллээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага өгөөгүй, шилэн дансны аудит, прогораммын алдаа нь дээр 2 зөвлөмж өгсөн ба хэрэгжилтийг ханган биелүүлсэн бана.

*Хүснэгт 4 Зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 2 | 15,000.0 | 2 | 15,000.0 | 100 |
| **Нийт дүн** | 2 | 15,000.0 | 2 | 15,000.0 | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийг гүйцэтгэлд суурилж олгож байгаагаас шалтгаалан, санхүүжилтийн орлого нэмэгдэж ирснээр дахин эмийн тендер зарлаж, худалдан авалт хийх шаадлагатай байсан ч, тухайн сумын Эрүүл мэндийн төв нь 61,231.9 мянган төгрөгийн тендергүй эмийн худалдан авалт хийсэн байна.
- Цэцэрлэг сумын ЗДТГ-аас 2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр тус сумын ЭМТ-ийн нэр дээр 88.0 сая төгрөгийн үнэ бүхий Прадо-150 суудлын авто машиныг худалдан авах тендер зарлаж сумын ИТХ-ын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 06-р тогтоолоор ЭМТ-ийн хөрөнгөнд шилжүүлэх тогтоол гарсан байна. ЭМТ нь хөрөнгийг биетээр хүлээж аваагүй байж данс бүртгэлд тусгасан байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 149,465.2 мянган төгрөгийн алдаа[3] илэрснээс аудитын явцад 84,456.8 мянган төгрөгийн алдааг залруулж, 65,008.4 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналд гарсан дараах алдааг залруулсан. Үүнд:

- ЭМД-аас 2021 оны ковидын авлага 75,124.3 мянган төгрөг авсан ба үүнийг 2022 оны мөнгөн гүйлгээний тайланд орлогын зүйл ангийг буруу сонгож тайлагнасан нь үнэн зөв гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Тайлант онд 9,332.5 мянган төгрөгийг зардал хооронд гүйлгэн эдийн засгийн ангилал буруу сонгож бүртгэснийг залруулсан болно.

Аудитаар нийт 65,008.4 мянган төгрөгийн зөрчил[4] илэрснээс, 65,008.4 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 3,201.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

---

[3] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[4] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримт бүрдүүлж ажиллах.

**2. Шилэн данстай холбоотой асуудал**

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй 61,806.9 мянган төгрөгийн 3 гүйлгээ мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| ЭМД-аас 2021 оны ковидын авлагыг Мөнгөн гүйлгээний орлогын тайланд зөрүүтэй тайлагнасан | 2 | 75,124.3 | | | 2 | 75,124.3 | 2 | 75,124.3 | | | | |
| Эдийн засгийн ангилал зөрүүтэй | 1 | 9,332.5 | | | 1 | 9,332.5 | 1 | 9,332.5 | | | | |
| Дүн | 3 | 84,456.8 | | | 3 | 84,456.8 | 3 | 84,456.8 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Анхан шатны баримт дутуу | 1 | 3,201.5 | | | | | 1 | 3,201.5 | | | | |
| Дүн | 1 | 3,201.5 | | | | | 1 | 3,201.5 | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| 6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ мэдээлээгүй байна. | 1 | 61,806.9 | | | | | 1 | 61,806.9 |
| Дүн | 1 | 61,806.9 | | | | | 1 | 61,806.9 |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ Х.ДИЙМАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Л.МАГСАРЖАЛАМ